НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2025он) | Зорилтот түвшин (2026он) | Хүрэх түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1:** Холбогдох хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний стандарт нэвтрүүлнэ. /Дүрмээр хүлээсэн чиг үүрэг/ | | | | | | | |
| Зорилт 1.1. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.1. Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон холбогдох байгууллагуудтай хамтран болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг нийслэлийн дүүргүүдэд зохион байгуулж, зорилтот бүлгийн архины хамааралтай, гэр оронгүй иргэдийг төвийн үйлчилгээнд хамруулж ажиллах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн дүүргүүдийн Цагдаагийн газар хэлтсүүдтэй хамтран ажиллаж, илрүүлэг арга хэмжээний хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт тэнүүчлэн амьдарч буй гэр оронгүй иргэдийг эрсдэлээс хамгаалах, асран хамгаалагч болон харгалзан дэмжигчид нь хүлээлгэн өгөх, халамжийн үйлчилгээнд хамруулах зорилгоор 32 удаагийн илрүүлгээр ирсэн 443 иргэнээс зорилтот бүлгийн 351, өөрийн хүсэлтээр ирсэн 199, нийт 550 иргэнийг хүлээн авч, зорилтот бүлгийн иргэдэд төвөөс үзүүлдэг 12 төрлийн үйлчилгээнд хамруулан ажилласан байна. | 100 |
| 2 | Арга хэмжээ 1.1.2. Төвөөр үйлчлүүлэгч иргэдэд нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийж, дамжин өнгөрүүлэх төвийн түр хоноглуулах, хоол, цай, хувцас солих гэх мэт суурь хэрэгцээг хангах үйлчилгээнд хамруулах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2026 оны эхний хагас жилд зорилтот бүлгийн 550 /давхардсан тоогоор 5939/ иргэнийг түр хоноглох байранд хоноглуулан, 17817 /давхардсан тоогоор/ иргэнд цэсийн дагуу өдөрт 3 удаа халуун хоол цайны үйлчилгээг үзүүлсэн байна.<br>Үйлчлүүлэгч иргэдээс авдаг сэтгэл ханамжийн судалгаа, 2026 онд орон тоо бий болж ажиллаж эхэлсэн хоол зүйчийн санал зөвлөмжид үндэслэн 1, 2 дугаар хоолны шинэ цэс гаргаж, үйлчилж байгаа нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байна. Мөн шинээр ирж буй иргэдийн нөхцөлийг үнэлж хүний анхдагч суурь хэрэгцээний дагуу хувцсыг сольж, халуун усанд оруулж, ариун цэвэр сахиулах цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3 | Арга хэмжээ 1.1.3. Үйлчлүүлэгч иргэдийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн бичиг баримтжуулах, | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Үйлчлүүлэгч иргэдийн дунд иргэний бичиг баримтгүй, зөрчилтэй 37 иргэний судалгааг гаргаж, 31 иргэнийг бичиг баримтжуулаад байна. Мөн шинээр 4 иргэнийг | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжид хамруулах, дараагийн шатлалын байгууллагад шилжүүлэх, ар гэрт нь эргэн нэгтгэх зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах. | | | | | тэтгэвэр тэтгэмжид хамруулан 6 иргэний тэтгэвэр, тэтгэмжийн сунгалт хийлгэж ажилласан.<br>Ахмад настай харж хандах гэр бүлгүй 5 ахмад настны нөхцөл байдлын үнэлгээг хийж, төрөлжсөн асрамжид шилжүүлэхээр материал бүрдүүлж, иргэний хаягийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлэн 4 иргэний шийдвэр гарч 3 иргэнийг Батгэрэлт-Ирээдүй, Териэза Эх, Шинэ амьдрал ялагч ТББ-д шилжүүлэн 1 иргэнийг Ахмад Настны Үндэсний төвд шилжүүлэхээр ажиллаж байна. Халамжийн үйлчилгээний хүртээмж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2% өссөн үзүүлэлттэй байгаа нь үйлчилгээний хүртээмж, холболт нэмэгдсэнийг харуулж байна. | |
| 4 | Арга хэмжээ 1.1.4. Төвийн эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлтийн алба сургалтын төлөвлөгөөний дагуу салбар төвүүдэд үйлчилгээ авч буй иргэдэд хувь хүний хөгжил төлөвшлийн олон талт сургалтуудыг зохион байгуулах. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 75 | 100 | Төвийн эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлтийн албаны сургалтын төлөвлөгөөний дагуу Дамжин өнгөрүүлэх төвд 14 удаагийн сургалтад 607 иргэн, Сургалт хөгжлийн цогцолбор төвд 43 удаагийн сургалтад 645 иргэн тус тус хамрагдаж нийт 57 удаагийн 57 цагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1252 иргэн хувь хүний хөгжил төлөвшлийн олон талт сургалтад хамрагдсан байна.<br>Сургалтаар дамжуулан хувь хүний нийгэмд зөв дасан зохицож, бусадтай үр дүнтэй харилцах мэдлэг ур чадвар, эерэг хандлагыг төлөвшүүлэхийг зорьж ажилласан бөгөөд үйлчлүүлэгч иргэдийн хичээлийн идэвх оролцоо, нээлттэй өөрийгөө илэрхийлэх байдал, бусадтай харилцах харилцаанаас сургалтын үр дүн харагдаж байна. | 97 |
| 5 | Арга хэмжээ 1.1.5. Тэнэмэл иргэд ихээр төвлөрдөг томоохон худалдааны төв, хаягдал түүхий эд худалдан авах цэгүүд гэх мэт газруудаар товлосон хугацаанд зорилтот бүлгийн иргэд, үйлчилгээний байгууллагуудад мэдээлэл түгээж ажиллах. | | Зохион байгуулсан ажлын тоо | 3 | 6 | Албан хаагчид 7-н багийн бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн 7 дүүргийн 2 дахь түүхий эд хүлээн авах цэг, зах худалдааны төвүүд, хогийн цэгүүд зэрэг гэр оронгүй тэнэмэл иргэд ихээр төвлөрдөг газруудад гадуур судалгааг 2 удаа зохион байгуулж ажилласан. Судалгаагаар нийт 498 иргэнд мэдээлэл хүргэж, 2 дахь түүхий эд авах 24 цэгээр очиж 20-н аж ахуй нэгжтэй уулзаж хамтарч ажилласан байна. Судалгааны хүрээнд 38 иргэн өөрийн хүсэлтээр төвийг зорин ирж үйлчилгээнд хамрагдсан байна. | 98 |
| 6 | Арга хэмжээ 1.1.6. Дамжин өнгөрүүлэх төвөөс шилжүүлсэн гэр | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Сургалт хөгжлийн цогцолбор төвд 8400 /давхардсан тоогоор/ иргэнийг, хоноглуулан 25200 /давхардсан | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оронгүй иргэдийг Цогцолбор төвд хүлээн авч хувь хүний хөгжлийн кэйс менежмент хийж, бие даалгахтай холбоотой хувь хүний хөгжлийн үйлчилгээнд хамруулах. | | | | | тоогоор/ иргэнд цэсийн дагуу өдөрт 3 удаа халуун хоол цайнд хамруул ажилласан. Мөн төвд үйлчилгээ авахыг зорин ирж буй иргэдийн хэрэгцээнд тохируулан хувцсыг сольж, халуун усанд оруулж, 3-н бүлэгт хуваарилан хөтөлбөрт хамруулан үйлчилгээ үзүүлж байна. | |
| 7 | Арга хэмжээ 1.1.7. Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүдийг угтсан төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгч иргэдэд өдөрлөг, спорт, соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулж ажиллах. | | Арга хэмжээний тоо | 15 | 30 | Нийгмийн хамгааллын тусгай төвөөр үйлчлүүлж буй иргэдэд зориулан нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүдийг угтаж цагаан сар, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, клубийн үйл ажиллагаа зэрэг нийт 15 ажил зохион байгуулж 1350 иргэн /давхардсан тоогоор/ хамрагдсан байна.<br>Үйлчлүүлэгчдийн дунд соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулснаар уламжлалт ёс заншлаа хадгалах, нийгмийн харилцаанд оролцох боломжоор хангагдаж, олон нийтийн дунд биеэ зөв авч явах чадварт суралцах, өөртөө итгэх итгэл нэмэгддэг нь гол үр дүн юм. | 97 |
| 8 | Арга хэмжээ 1.1.8. Цогцолбор төвөөс үйлчилгээ авч буй иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, буруу зуршлыг багасгах зорилгын хүрээнд “Бие даасан иргэдийн амжилт”-ын өдөрлөгийг зохион байгуулах. | | Зохион байгуулсан өдөрлөгийн тоо | - | 2 | Сургалт хөгжлийн цогцолбор төвийн болон нийт иргэдэд өөрийн амжилтын түүхийг хуваалцаж, бусдад үлгэр дуурайлал үзүүлэх “Амжилтын өдөрлөг” сэдэвтэй үйл ажиллагааг 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.<br>Тус үйл ажиллагаагаар 1А бүлгийн нийт 18 иргэн төгссөн ба иргэдийн өөрийн амжилтын түүхийг хуваалцаж бусдад үлгэр дуурайлал үзүүлэх, хамтын хүчний үнэ цэнийг онцолж, урам зориг өгөх зорилготойгоор тэдний амжилтыг баталгаажуулж, гэрчилгээ болон дурсгалын зүйл олгож ажилласан. | 100 |
| 9 | Арга хэмжээ 1.1.9. Сургалт хөгжлийн цогцолбор төвөөр үйлчлүүлж буй иргэдийг Нийгэмшүүлэх цогц хөтөлбөрийн дагуу бие даасан амьдралд шилжүүлэн ажиллах. | | Үйлчлүүлсэн иргэдийн нийгэмшсэн хувь | 3 | 10 | Тайлант хугацаанд Дамжин өнгөрүүлэх төвөөс 204, Сургалт хөгжлийн цогцолбор төвөөс 12 нийт 216 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, төвөөр үйлчлүүлэгчдээс архины хамаарлын 1 дүгээр түвшний 18 иргэн хөтөлбөрөө дүүргэж, ажилд зуучлагдан бие даасан амьдралд шилжих бэлтгэлээ хангаж эхлээд байна.<br>Эдгээр 18 иргэн 2026 оны 2 дугаар хагаст хувь хүний хөгжлийн төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар төвөөс гарч, бие даасан амьдралд шилжих юм. Үйлчлүүлэгчдийг бие даасан амьдралд шилжүүлэх энэхүү үзүүлэлт нь 2025 оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байгаа нь эрүүл мэнд нийгэм сэтгэл зүй | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөр эрхлэлтийн цогц хөтөлбөр, арга зүйг боловсруулан, хэрэгжүүлж эхэлсний үр дүн гэж үзэж байна. | |
| | Зорилт 1.2. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 1.2.1. Төвөөс үйлчилгээ авч буй иргэдэд сэтгэл зүйн анхан шатны үнэлгээ (донтолтын түвшин тогтоох, сэтгэц оношилгоо) хийж ажиллах. | | Хамрагдсан иргэдийн тоо | 353 | 500 | Төвөөс үйлчилгээ авч буй иргэдэд сэтгэл зүйн анхан шатны үнэлгээ (донтолтын түвшин тогтоох, сэтгэцийн оношилгоо) хийх ажлыг тогтмол зохион байгуулж, тайлант хугацаанд нийт 508 иргэнийг хамруулан үнэлгээ хийж ажиллалаа.<br>Үнэлгээний үр дүнд иргэдийн донтолтын эрсдэл, сэтгэл зүйн эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлон, цаашдын зөвлөгөө, үйлчилгээ, сэтгэл зүйн засал боловсруулах суурь мэдээллийг бүрдүүлсэн. Ингэснээр үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг судалж тэдэнд чиглэсэн дэмжлэг, хөндлөнгийн оролцоог илүү оновчтой төлөвлөх боломж бүрдэж, сайжирсан. | 100 |
| 11 | Арга хэмжээ 1.2.2. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, заслын үйлчилгээг үзүүлэх. | | Хамрагдсан иргэдийн тоо | 343 | 500 | Төвөөс тогтвортой үйлчилгээ авч буй нийт 3 бүлгийн 99 иргэнд давхардсан тоогоор 635 удаагийн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, заслын үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.<br>Үйлчилгээний хүрээнд сэтгэл хөдлөлөө танин мэдэх, зохицуулах, стрессийг даван туулах, асуудал шийдвэрлэх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн танин мэдэхүйн зан үйлийн арга, сэтгэл хөдлөлийн зохицуулалтын дасгал, анхаарал төвлөрөл хөгжүүлэх техник, оюуны чадамжийг дэмжих сэтгэл зүйн дасгал, үнэлгээний аргуудыг ашиглав.<br>Үүний үр дүнд иргэдийн өөрийгөө ойлгох ойлголт нэмэгдэж, сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал, асуудлыг эргээр шийдвэрлэх хандлага, өдөр тутмын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар нэмэгдэж байна. | 98 |
| 12 | Арга хэмжээ 1.2.3. Салбар төвүүдээр үйлчлүүлж буй иргэдийг сэтгэл зүйн үнэлгээний дагуу бүлгийн зөвлөгөөнд хамруулах. | | Иргэдийн хамрагдалтын тоо | 713 | 800 | Салбар төвүүдээр үйлчлүүлж буй иргэдийг сэтгэл зүйн үнэлгээний үр дүнд үндэслэн хэрэгцээ, онцлогт нь тохирсон бүлгийн зөвлөгөөнд хамруулан ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 507 иргэнийг 292 цагийн бүлгийн зөвлөгөө, сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулсан.<br>Зөвлөгөөний явцад бихевиорист, когнитив болон хүмүүнлэгийн сэтгэл судлалын арга техникүүдийг | 99 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглан оролцогчдын зан үйлийн өөрчлөлтийг дэмжих, эерэг сэтгэлгээ төлөвшүүлэх, өөрийгөө ойлгох ойлголтыг нэмэгдүүлэх, харилцаа болон нийгмийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэн ажиллав. Зөвлөгөөний үр дүнд иргэдийн бүлгээр ажиллах идэвх оролцоо нэмэгдэж, сэтгэл зүйн асуудлаа танин мэдэх, даван туулах арга барил эзэмших, өөрчлөлт хийх сэдэл тэмүүлэл нь дээшилсэн эерэг үр дүн гарсан. | |
| 13 | Арга хэмжээ 1.2.4. Өмнөх жилүүдэд бие даасан амьдралд шилжсэн иргэдтэй эргэх холбоо тогтоож, амьдралын нөхцөл, байдлыг судалж дэмжлэг шаардлагатай иргэдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллах. | | Зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо | 21 | 40 | Өмнөх жилүүдэд бие даасан амьдралд шилжсэн иргэдтэй эргэх холбоо тогтоох, амьдралын нөхцөл байдал, нийгэмшлийн явцыг судлах ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд нийт 18 иргэнтэй холбогдон мэдээлэл цуглуулж ажиллалаа. Судалгааны үр дүнд иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн орчин, нийгэмд дасан зохицсон байдал болон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, шаардлагатай 12 иргэнд нийгэм, сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан. | 97 |
| Зорилт 1.3. Эрүүл мэндийн үйлчилгээ | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 1.3.1. Үйлчлүүлэгч иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэн дараагийн шатлалын эмнэлгийн үйлчилгээнд зуучлах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төвөөр үйлчлүүлсэн 550 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Давхардсан тоогоор 2000 иргэн хамрагдсан. Нийт 35 иргэнийг дараагийн шатлалын эмнэлэгт зуучилж, хэвтэн эмчлүүлсэн байна. СЭМҮТ-2 иргэн УГТЭ-2 иргэн УНТЭ-2 иргэн ХСҮТ-д 2 иргэн ХӨСҮТ-д 7 иргэн СХДНЭ-т 20 Энэрэл эмнэлэгт 18 иргэнийг хэвтүүлэн эмчилгээ хийлгэсэн. ЦЕШ, ШЕШ, Биохими, ЗЦБ, шүд, хөнгөлөлттэй эм бичүүлэх үйлчилгээнд давхардсан тоогоор 110 иргэн хамрагдсан. Дотрын өвчний чиглэлээр оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллаж, шаардлагатай баримт бичгийг бүрэн бүрдүүлэн хүргүүлж, холбогдох шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулав. Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой бүрдүүлэлт, бэлтгэл ажил бүрэн хангагдсан бөгөөд холбогдох байгууллагын шийдвэрлэх шатанд ажил үргэлжилж байна. | 99 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 1.3.2. Үйлчлүүлэгч иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах. /эхо, дотор, мэс засал, арьс өнгө, сүрьеэ, мэдрэл, эмэгтэйчүүд/ | | Зохион байгуулсан үзлэгийн тоо | 4 | 6 | Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран 4 удаагийн үзлэгээр 117 иргэнийг цээжний рентген зураг цэрний шинжилгээнд хамруулсан.<br>СХДЭМТ-ийн ДОХ, БЗДХӨ кабинеттай хамтран 41 иргэнд дох, тэмбүү, элэгний В,С вирусийн маркер тодорхойлох шинжилгээнд хамруулсан.<br>Нарийн мэргэжлийн шинжилгээний хариугаар БЗХӨ, Syphilis-10, Hepatitis B Virus-3, Hepatitis C Virus-3 тус тус илэрсэн.<br>Төгс бүсгүйчүүд ТББ, Зөв найзууд ТББ хамтран 33 иргэнийг ЗДХӨ, сүрьеэ, элэгний В,С вирусийн шинжилгээнд хамруулсан. Глобал сангийн урьдчилан сэргийлэх үзлэгт 24 иргэн хамрагдсан.<br>2026 оны эхний хагас жилд нийт-215 иргэн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байна. | 96 |
| 16 | Арга хэмжээ 1.3.3. Үйлчлүүлэгч иргэдийг донтолтоос гарах сайн дурын эмчилгээ, хордлого тайлах эмчилгээ болон дуршил бууруулах бүлгийн эмчилгээнд хамруулах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамрагдсан иргэдийн тоо | 26 | 50 | Сургалт хөгжлийн цогцолбор төвд 97, Дамжин өнгөрүүлэх төвд 210, нийт 307 иргэнд хордлого тайлах стандартыг баримтлан эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн. Нийслэлийн Аддиктологи Зан Үйл, Сэтгэл заслын төвд 15 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулснаас, Сайн Санаа Сайхан Сэтгэл-4С эмчилгээнд 2-иргэн хордлого тайлах эмчилгээ болон дуршил бууруулах бүлгийн эмчилгээнд 13 иргэнийг тус тус хамруулсан. | 98 |
| 17 | Арга хэмжээ 1.3.4. Иргэдийн нөхцөл байдлыг үнэлж нэн шаардлагатай иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамрагдсан иргэдийн тоо | 40 | 50 | Эрүүл мэндийн зайлшгүй тусламж шаардлагатай, ЭМД төлөөгүй орлогогүй 3 иргэнд байгууллагын зүгээс 812 мянган төгрөгийн зардлаар даатгалд хамруулж, эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн.<br>Сургалт хөгжлийн цогцолбор төв болон Дамжин өнгөрүүлэх төвөөр үйлчлүүлж буй иргэдээс 25 иргэн ар гэрээсээ болон эх орны хишиг зэрэг орлогоосоо ЭМД—д хамрагдсан.<br>Эмч, сувилагч нарын зүгээс 5 удаагийн гэгээн өглөөгөөр нийт давхардсан тоогоор 520 иргэнд ЭМД-д хамрагдаагүйн улмаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс хоцрох эрсдэлийн талаар зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгч, иргэдэд ЭМД-д хамрагдалтын талаар зөвлөж эмч, нийгмийн ажилтнууд хамтран ажилласны үр дүнд нийт 28 иргэн, ЭМД-д хамрагдсанаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй гарсан байна. | 99 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Арга хэмжээ 1.3.5. Нөхөн сэргээх эмчилгээ бүхий чийрэгжүүлэлтийн кабинетын тогтвортой байдлыг хангаж, төвөөр үйлчлүүлж буй иргэдэд хуваарийн дагуу нөхөн сэргээх эмчилгээ, чийрэгжүүлэх үйлчилгээг үзүүлж ажиллах. | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нөхөн сэргээх эмчилгээ бүхий чийрэгжүүлэлтийн кабинетаар иргэдэд үйлчилгээ үзүүлэх явцад ханиад, томуу, артерийн даралт ихсэлт, хэсэг газрын булчин чангаралт болон үений өвчлөл зонхилон тохиолдсон тул Сэргээн засах тусламж үйлчилгээг иргэдэд цаг алдалгүй үзүүлж, уламжлалт анагаах ухааны эм тан, бумба, эмчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Эмчилгээний үр дүнгийн нэгдсэн дүгнэлт: Тайлант хугацаанд нөхөн сэргээх эмчилгээний тасагт нийт 392 үйлчлүүлэгч давхардсан тоогоор 2,260 удаагийн тусламж үйлчилгээнд хамрагдсан байна.<br>Үүнээс эмчилгээний үр дүнг тооцоход нийт үйлчлүүлэгчдийн 89.8% буюу 352 нь зовуурь шаналгаа бүрэн арилсан, хөдөлгөөний далайц сайжирсан үр дүнтэйгээр эмчилгээг дуусгасан байна.<br>Эмчилгээний төрлөөс массажны сандал (95%) болон УВЧ аппарат (91%) хамгийн өндөр үр дүнтэй байсан бол, нуруу татлага эмчилгээ (84.3%)-ийн үр дүнтэй гарсан байна. Нуруу татлагын эмчилгээний хувьд харьцангуй урт хугацаанд үр дүн гардаг онцлогтой юм. | 98 |
| 19 | Арга хэмжээ 1.3.6. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, яаралтай үед анхны тусламж үзүүлэх, бэлэн байдлыг хангах талаар үйлчлүүлэгч иргэдэд болон албан хаагчдад сургалт, дадлагажуулалд, мэдээлэл зохион байгуулж ажиллах. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | 4 | Эрүүл мэндийн баг нийт 12 удаагийн сургалтаар иргэдэд халдварт ба халдварт бус зонхилон тохиолдох өвчлөлийн талаар, эрүүл мэндийн боловсрол олгох урьдчилан сэргийлэх арга замууд эрсдэлээс өөрийгөө урьдчилан сэргийлэх анхны тусламж үзүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 210 иргэнд сургалт зохион байгуулав.<br>ХАБЭА-н ажилтан, эмч сувилагч нар хамтран ахуйн болон осол гэмтлийн талаар сургалт зохион байгуулж нийт 140 иргэн хамрагдсан байна.<br>Хууль эрх зүйн ажилтан, ХАБЭА-н ажилтан, эмч сувилагч нар хамтран мэдээллийн самбар ажиллуулж, иргэдэд эрүүл мэнд, цаг үеийн болон аюулгүй байдал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна. | 98 |
| 20 | Арга хэмжээ 1.3.7. Байгууллагын ариутгал, халдваргүйжүүлэлтийг норм стандартын дагуу дамжин өнгөрүүлэх болон сургалт хөгжлийн | Батлагдсан төсвийн хүрээнд | Зохион байгуулсан тоо | 3 | 8 | Дамжин өнгөрүүлэх төв дээр халдвар хамгааллын дэглэм стандартын дагуу зориулалтын ариутгалын бодисоор тус үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр норм стандартын дагуу 4 удаа | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цогцолбор төвүүдэд улирал бүр давтамжтай зохион байгуулах. | | | | | ариутгал гүйцэтгүүлэн халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажилласан. | |
| Зорилт 1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ | | | | | | | |
| 21 | Арга хэмжээ 1.4.1. Үйлчлүүлэгч иргэдийн амьдарч буй байранд хуваарийн дагуу камерын хяналт, согтууруулах, мансууруулах бодис, хүний биед гэмтэл учруулж болзошгүй эд зүйлсийн үзлэг хийж, зөрчил гаргасан иргэдэд хариуцлага тооцож ажиллах. | | Зохион байгуулсан ажлын тоо | 21 | 48 | Төвийн хууль эрх зүйн ажилтан 2026 оны эхний хагас жилд Сургалт хөгжлийн цогцолбор төв дээр 4, Дамжин өнгөрүүлэх төвд 6, нийт 10 удаагийн хориотой зүйлийн үзлэг, камерын хяналт шалгалт, жижүүрийн работын үзлэгүүдийг тус тус хийж, нийт 40 хутга, 3 ширхэг хайч хураан авч устгалд оруулан, албан хаагчид болон үйлчлүүлэгч иргэдэд зөвлөмж өгч ажилласан байна.<br>Түүнчлэн бусадтай таарамжгүй харилцан зөрчил гаргасан 4 иргэнтэй ганцаарчилсан уулзалт зохион байгуулж хууль эрх зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан байна. | 96 |
| 22 | Арга хэмжээ 1.4.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар бусад холбогдох байгууллагуудтай хамтран гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр түвөөр үйлчлүүлж буй иргэдэд лекц зөвлөгөө зохион байгуулах. | | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 6 | Тайлант хугацаанд Сургалт хөгжлийн цогцолбор төв, Дамжин өнгөрүүлэх төвүүдээр үйлчлүүлэгч иргэдэд нийт 8 удаагийн зохион байгуулалтаар Гэмт хэрэг ба харилцаа, Эрүүгийн хариуцлага, Зөрчлийн хариуцлага, Гэр бүлийн харилцаа сэдэвт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, лекц зохион байгуулж, давхардсан тоогоор 416 иргэнийг хамруулсан байна.<br>Түүнчлэн 2026 оны хоёрдугаар хагаст Нийслэлийн дүүргүүдийн Цагдаагийн газар хэлтсүүдийн албан хаагчидтай хамтран төвөөр үйлчлүүлэгчдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулахаар уулзалт хийж ажиллалаа. | 96 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2:** Үйлчлүүлэгч иргэдийн амьдралын буруу дадал хэвшлийг өөрчлөх, бие даасан амьдралд бэлтгэх, сургалт, хөгжил, соёлын цогц арга зүй, хөтөлбөрийг хөгжүүлж хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 23 | Арга хэмжээ 2.1. Гэр оронгүй иргэдтэй ажиллах арга зүй, нийгэмшүүлэх сургалт, хөгжлийн цогц хөтөлбөр, гарын авлага боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 40 | 100 | Гэр оронгүй иргэдтэй ажиллах арга зүй, нийгэмшүүлэх сургалт, хөгжлийн цогц хөтөлбөрийн ахисан шатны агуулга болох дэд хөтөлбөрийн боловсруулалтыг 2026 оны 01 дүгээр улиралд багтаан дуусгаж хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн.<br>Олон улсын туршлага, шинжлэх ухааны дэвшилд суурилсан цогц хөтөлбөр, арга зүйг Сургалт хөгжлийн цогцолбор төвд хэрэгжүүлж эхэлснээр 3 сарын дотор эхний 18 үйлчлүүлэгч хөтөлбөрийг амжилттай дүүргэж, ажлын байранд зуучлагдаж, дараагийн шатны 28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлүүлэгч 7 дугаар сард хөтөлбөрийг дүүргэхээр ажиллаж байна.<br>Эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний дэс дараалал, уялдаа холбоо, гүйцэтгэл, чанар, үр дүнг сайтар тооцоолсон энэхүү арга зүй, хөтөлбөр цаашид үр дүнтэй, урт хугацаанд тогтвортой хэрэгжих магадлал өндөр байгаа нь өнгөрсөн хугацаанд судалж, боловсруулалт хийсэн ажлуудын үр дүн юм.<br>Түүнчлэн энэхүү арга зүй, дэд хөтөлбөр төвийн үйлчилгээнд нэвтэрч, үр дүн гарч эхэлснээр байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилгын хэрэгжилт хангагдаж байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3:** Ажлын байр, мэргэжлийн сургалт, бүтээлч үйл явцыг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж бие даасан амьдралд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр | | | | | | | |
| 24 | Арга хэмжээ 3.1.1. Үйлчлүүлэгч иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр хүргэх, хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ буюу профайлинг хийх. | | Хамрагдсан иргэдийн тоо | 50 | 150 | Сургалт хөгжлийн цогцолбор төвд байрлаж буй үйлчлүүлэгч иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг бүлгийн хэлбэрээр 77 иргэнд ганцаарчилсан хэлбэрээр 80 иргэнд өгсөн байна.<br>Үйлчлүүлэгчдийн ажиллах нөөц бололцоо, ур чадварыг тодорхойлох профайлинг үйлчилгээг 72 иргэнд хийснээр уг иргэдийн сонирхол, ур чадвар зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг таньж мэдэн цаашид ажлын байранд зуучлагдах, тогтвортой хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг болсон. | 98 |
| 25 | Арга хэмжээ 3.1.2. Ажил олгогч болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үйлчлүүлэгч иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажлын байрны тогтвортой байдлыг хангахад анхаарч, хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой дэмжих. | | Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо | 165 | 200 | Ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй “Ганц зам итгэл” ТББ, “Каритас монгол” ТББ, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв, Монголын хараагүйчүүдийн холбоо, “Зөв итгэл найзууд” ТББ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, зарим байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>Японы ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд иргэдийг Ажилд турших хөтөлбөрт хамруулан ажиллав.<br>Харуул хамгаалалтын “Сайхан хүлэг” ХХК, Барилгын үйл ажиллагаа явуулдаг “Шавар заан” ХХК компани болон | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь хүмүүстэй хамтран ажиллаж тайлант хугацаанд нийт 88 иргэн тогтвортой болон түр ажлын байранд зуучлагдсан. Дотоодын оёдлын цех, хүлэмжийн аж ахуйг түшиглэн 7 иргэнийг түр ажлын байраар хангасан бөгөөд нийт 95 иргэн ажлын байранд хамрагдсан байна.<br>Нийтийг хамарсан ажилд иргэдийн сайн дурын оролцоог хангаж ажиллах арга хэмжээний хүрээнд 2 удаагийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулсан байна.<br>2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Сургалт хөгжлийн цогцолбор төвийн үйлчлүүлэгч иргэд, албан хаагчид нийт 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллагын гадна талбай болон БЗД-ийн 35-р хороо Улиастайг ам орчмын нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэж, 40 орчим шуудай хог ачуулсан.<br>Мөн үйлчлүүлэгч 15 иргэн, Баянзүрх дүүргийн 35-р хорооны 7-р хэсэг, 10-р хэсгийн ахлагч нартай хамт тус хэсгүүдийн нийтийн эзэмшлийн газрыг цэвэрлэж 25 орчим шуудай хог ачуулж ажилласан. | |
| 26 | Арга хэмжээ 3.1.3. Сургалт хөгжлийн цогцолбор төвд оёдол эсгүүр, модон эдлэл, жимс жимсгэнийн тариалалт, мод үржүүлгийн чиглэлээр үйлчлүүлэгч иргэдийг сургалтад хамруулан дадлагажуулж ажиллах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | - | 25 | Сургалт хөгжлийн цогцолбор төвөөр үйлчлүүлж буй иргэд цэцэрлэгчин бэлтгэх, хүлэмжийн аж ахуйн сургалт, оёдлын сургалтад өдөр бүрийн хуваарийн дагуу онолын болон практик хичээлд хамрагдаж байна.<br>Хүлэмжийн аж ахуйн сургалтад хамрагдсан иргэд лооль, хэмх, байцайны 4000 ширхэг үрсэлгээ хийж, хүлэмжид шилжүүлэн ажиллаж байна.<br>Нэг наст цэцгэн байгууламжийг бий болгох, мод, сөөг суулгах, усалгаа хийх, байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, мод, сөөг хэлбэржүүлэх, шохойдох, модны нүх ухах, зуны арчилгаа хийх зэрэг ажлуудад стандартын дагуу сурч арга барилыг эзэмшин тахиан залаа, хун цэцэг, астра, хилэн хар, мандарваа цэцгийн 8000 үрсэлгээг бойжуулсан.<br>Оёдлын сургалтад хамрагдсан 28 иргэн шулуун оёдол, хэрээсний машинаар оёх анхан шатны мэдлэг практикт суурилсан сургалтад хамрагдаж, ил болон төрөл бүрийн халаас оёж сурсан. | 98 |
| Зорилт 3.2.Төсөл хөтөлбөрийн чиглэлээр “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийн хүрээнд | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | Арга хэмжээ 3.2.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Сургалт хөгжлийн цогцолбор төвийг түшиглэн “Хамтдаа тарьж, хамтдаа ургуулъя” 10,000 мод тарьж ургуулах төслийг хэрэгжүүлэх. | | Тарьсан модны тоо | 500 | 2000 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд: төвийн албан хаагчдын санаачилгаар 2026 оны хаврын мод тарих өдрүүдийг тохиолдуулан “Хүн бүр мод тарья” аяныг зарлаж, олон нийтэд түгээн дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна:<br>Төвийн албан хаагчид аянд нэгдэж Сургалт хөгжлийн цогцолбор төвийн хашаанд хамгаалалтын зурваст навчит төрлийн 200 ширхэг суулгацыг суулгасан.<br>“Сод Монгол Групп” ХХК-ийн Улаанбаатар нефть хангамжийн газрын хамт олон 5 сая орчим төгрөгийн үнийн дүн бүхий 130 ширхэг нарсны тарьц суулгасан.<br>”Хурх-88” болон “Андууд” ТББ явган алхалтын клубууд хамтарч өөрсдийн хөрөнгөөр 440 ширхэг шар хуайсыг худалдан авч суулгасан.<br>Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүсэлт хүргүүлэн ажилласнаар тус байгууллагаас 1200ш улиас, бургасны суулгацыг хүлээн авч, түр хадгалан тарилтад бэлтгэж байна.<br>Түүнчлэн Нийслэлээс ирсэн хаврын мод тарих хуваарийн дагуу 5 дугаар сарын 10-ны өдөр ХУД-ийн Айцын аманд 175ш навчит төрлийн модыг төвийн албан хаагчдын төлөөлөл тарьж, услан хүлээлгэн өгсөн.<br>Тайлант хугацаанд Сургалт хөгжлийн цогцолбор төвийн ил талбайд болон Нийслэлээс заасан хуваарьт талбайд нийт 5 аж ахуйн нэгж байгууллага, 10 гаруй хувь хүмүүсийн дэмжлэг, төвийн албан хаагчид, үйлчлүүлэгч иргэдийн хамтын оролцоотойгоор нийт 1132 ширхэг шилмүүст олон навчит төрлийн модыг суулган, усалж, арчлан ургуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн байгаль орчиндоо хувь нэмэр оруулан ажилласан байна. | 100 |
| 28 | Арга хэмжээ 3.2.2 Сургалт хөгжлийн цогцолбор төвийг түшиглэсэн “Мод үржүүлгийн газар байгуулах” төслүүдийг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 20 | 40 | “Мод үржүүлгийн газар байгуулах”-аар хөрс боловсруулалтын бэлтгэл ажил хийгдэж, чацарганын төгөл үүсгэх зорилгоор 60 ширхэг чацарганын суулгац суулган усалж, арчлан ургуулж байна. | 80 |
| 29 | Арга хэмжээ 3.2.3 Сургалт хөгжлийн цогцолбор төвийг түшиглэсэн “Жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл хэрэгжүүлэх. | | Гүйцэтгэлийн хувь | 20 | 70 | 2025 онд хагалж уринш хийсэн 0,5 га талбайг дахин хагалуулж, борнойдуулж, үйлчлүүлэгч иргэд албан хаагчид хамтран том хэмжээтэй чулуу, үндэс зэргийг түүж, ногоо тарих талбай, хүлэмж байгуулах талбайг бэлтгэн ажилласан. 6х35м хэмжээтэй зуны нийлэг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хальсан хүлэмжийг барьж, өргөст хэмхийн 1000ш үрсэлгээ, салатны навч 100м2 талбайд тус тус шилжүүлэн суулгаж, усалгаа арчилгааг гүйцэтгэн ажиллаж байна. Түүнчлэн хүлэмжийн ногоо тарилтад 3 иргэн түр ажлын байраар хангагдан ажиллаж байна. | |
| 30 | Арга хэмжээ 3.2.4. 2019-2020 онд Австралийн ЭСЯ-ны дэмжлэгтэй “Ногоон хэрэглээг дэмжих замаар эмзэг бүлгийн иргэдийн эдийн засгийг бэхжүүлэх” төслийн хүрээнд байгуулагдсан оёдлын цехийг өргөтгөн, үйл ажиллагааг тогтмолжуулж, төвийн үйл ажиллагаанд шаардлагатай зарим оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эхлүүлж, үйлчлүүлэгч иргэдийг түр ажлын байраар хангаж, ур чадварт сургаж, орлогыг нэмэгдүүлэх. | | Гүйцэтгэлийн хувь | 50 | 80 | Сургалт хөгжлийн цогцолбор төвийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн дагуу Шулуун оёдлын машин-2, Хэрээсний машин-1, Канза машин-1, Товчны нүх хэрдэг машин-1, Товч хадагч машин-1, Хос оёдлын машин-1, Бөхөлгөөний машин-1 нийт 8 оёдлын машинаар оёдлыг цехийг өргөтгөснөөр оёдлын ажлыг хөнгөвчилж бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, хүчин чадал 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>Сургалт хөгжлийн цогцолбор төвөөр үйлчлүүлж буй иргэдийг оёдлын сургалтад хамруулж ажилласнаар идэвхтэй сайн суралцаж буй иргэдээс 4 иргэн аяны цүнх оёж, түр ажлын байранд хамрагдаад байна. Цаашид оёмол бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, оёдлын цехээр суралцагчдын ур чадварыг нь нэмэгдүүлэн, нэг дор 10 иргэнийг ажлын байраар ханган оёдлын цехийн үйл ажиллагааг жилийн 4 улирал тогтворжуулах боломж бүрдэж эхэлж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дотооддоо дэмжиж буй үр дүнтэй ажил болж байна. | 95 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 4:** Салбарын болон Олон улсын судалгаанд суурилсан арга зүйг хөгжүүлж, нийгэмд гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж ажиллана. | | | | | | | |
| 31 | Арга хэмжээ 4.1. Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх зорилтын хүрээнд дүүргүүдийн ЗДТГ-ийн Нийгмийн хөгжлийн хэлтсүүдэд сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах. | | Хамтын ажиллагааны тоо | 3 | 6 | СХД, БЗД-ийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цагдаагийн газар хэлтсүүд, Эрүүл мэндийн төв, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон Налайх дүүргийн ИТХ-ын даргатай гэр оронгүй иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж ажилласан.<br>Дээрх зөвлөлдөх уулзалтуудын үр дүнд байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирч, нийгмийн үйлчилгээний зохицуулалт, хамтын шийдвэр гаргалт илүү сайжирсан байна. | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | Арга хэмжээ 4.2. Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд цахим сэтгэл зүйн зөвлөгөөг зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх. | | Хамрагдсан хүний тоо | 82 | 100 | Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: “Каритас Монгол” ТББ-аар үйлчлүүлж архины хамааралтай, тэнүүчлэн амьдардаг эрсдэлт бүлгийн 120 иргэнд болон ШШГЕГ-ын харьяа 413-р хорих ангийн суллагдах дөхөж буй нийт 65 хүмүүжигч нарт “Сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгуулж Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээлэл хүргэж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.<br>Түүнчлэн ШШГЕГ-ын харьяа 405-р хаалттай хорих ангид ял эдэлж буй 50 хүмүүжигчид ‘’Гомдол, Уучлал Хайр ’’ сэдэвт зөвлөгөөг цахимаар зохион байгуулсан.<br>Ял эдэлж буй 12 хүмүүжигчид танхимаар сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 33 | Арга хэмжээ 4.3. Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн дархлааг дэмжих сэтгэл зүйд суурилсан нөлөөллийн контент боловсруулж олон нийтэд түгээн ажиллах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Контентийн тоо | 1 | 5 | Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн ажил сэтгэл зүйн агуулга бүхий нийт 3 видео контент боловсруулан бэлтгэж, төвийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн бөгөөд төвөөр үйлчлүүлж буй иргэдэд мөн тус контентыг үзүүлж, мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 96 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 5:** Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ | | | | | | | |
| 34 | Арга хэмжээ 5.1. Байгууллагын бүтэц орон тоо шинэчлэгдэж, үйл ажиллагаа өргөжсөнтэй холбогдуулан байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | Төвийн үйл ажиллагаа өргөжиж, Сургалт хөгжлийн цогцолбор төв ашиглалтад орж, Эрүүл мэнд нийгэм сэтгэл зүй хөдөлмөр эрхлэлтийн цогц хөтөлбөрөөр иргэдэд үйлчилж, үйлчлүүлэгч иргэдийг дунд хугацаанд нийгэмшүүлэх мөн түр байрлуулах үйлчилгээг үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулж ажилласан бөгөөд Нийслэлийн ЗДТГ-т төслийг хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 85 |
| 35 | Арга хэмжээ 5.2. Байгууллагын соёл, манлайлал, хяналт, удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангах, урамшууллын тогтолцоог шинэчлэх. | | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | Төвийн үйл ажиллагаа өргөжиж, бүтэц шинэчлэгдэж, Сургалт хөгжлийн цогцолбор төв ашиглалтад орсонтой холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, архив албан хэрэг хөтлөлт зэрэг журам гэрээнүүдийг шинэчилсэн.<br>Түүнчлэн байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй 1 дүрэм, 9 журмыг албан хаагчдад цахим болон цаасан суурьтай | 97 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлбэрээр танилцуулж, хууль эрх зүйн болон, ХАБЭА-н буланг тогтмол ажиллуулж байна. | |
| Зорилт 5.1 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах | | | | | | | |
| 36 | Арга хэмжээ 5.1.1. Ажлын байрны сул орон тоог төвийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж, сонгон шалгаруулалт, хүний нөөцийн бүрдүүлэлтийг тухай бүр хийж ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Сургалт хөгжлийн цогцолбор төв шинээр ашиглалтад орсонтой холбоотой шинээр нэмэгдсэн ажлын байрны орон тоог бүрдүүлэн, сонгон шалгаруулалт хийж ажилласан.<br>Байгууллагын цахим хуудас болон ажлын зарын сайтуудаар дамжуулан олон нийтэд нээлттэйгээр нийт-11 удаагийн ажлын зар байршуулан, 73 ажил горилогчийн анкет, хүсэлт хүлээн авч, 34 албан хаагчийг сонгон шалгаруулж нөхөн бүрдүүлэлт хийж ажилласан байна. | 98 |
| 37 | Арга хэмжээ 5.1.2. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган, үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн улирал бүр ур чадварын нэмэгдэл, хагас, бүтэн жилээр үр дүнгийн урамшуулал олгож, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган, ур чадвар, үр дүнг олгох журмын дагуу 1 дүгээр улиралд ажилтнуудын тайланд үндэслэн ур чадварын нэмэгдэл олгож ажилласан. Мөн 2 дугаар улирлын ур чадвар, хагас жилийн үр дүнгийн урамшууллуудыг тус тус үнэлэн олгохоор ажиллаж байна. | 100 |
| 38 | Арга хэмжээ 5.1.3. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулж, төлөвлөгөөний дагуу мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд албан хаагчдыг сургалт хөгжлийн үйл ажиллагаанд хамруулж, мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр суралцахад нь ажлын цагийн зохицуулалт хийж дэмжлэг үзүүлэх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төлөвлөгөөний дагуу Багш боловсролын шинэчлэл ТББ, Олон нийтийн хөгжилд их үйлс ТББ, НЗДТГ, Хүний нөөцийн хөгжлийн төв, Амжилтын алхам байгууллага болон дотооддоо зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 104 албан хаагч хамрагдаж, мэдлэг, ур чадвараа хөгжүүлсэн.<br>Мөн төвийн уламжлалтын их эмч анагаах ухааны тэргүүлэх зэрэг, хууль эрх зүйн ажилтан сэтгэл судлалаар давхар суралцаж бакалаврын зэрэг тус тус хамгаалсан байна.<br>Албан хаагчдыг сурч хөгжиж, мэдлэг чадвараа нэмэгдүүлэхэд хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалин чөлөөгөөр цагийн зохицуулалт хийж дэмжиж ажилласан байна. | 95 |
| Зорилт 5.2. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах | | | | | | | |
| 39 | Арга хэмжээ 5.2.1. “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” боловсруулж, хөтөлбөрийн дагуу | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Байгууллагад 20 гаруй жил үр бүтээлтэй ажиллан гавьяаны амралтаа авсан гурван хүний төрийн | 88 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах. | | | | | дээд шагналын асуудлыг Ерөнхийлөгчийн тамгын газар уламжлан, шийдвэрлүүлж ажиллалаа.<br>Түүнчлэн байгууллагын 20-н албан хаагчийг Төрийн ордонд оруулж, УИХ-ын гишүүн О.Саранчулуунтай уулзуулан, Парламентын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Сар шинийн баярыг угтан төвөөс тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн 1,200,000 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.<br>Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нийт 14 ажилтныг хөдөлмөрийн дотоод журмын дагуу сургалт, эрүүл мэнд, гадаадад туршлага судлах чиглэлд хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай чөлөөгөөр дэмжлэг үзүүлсэн байна.<br>Нийгмийн баталгааг хангах, сайжруулах зорилгын хүрээнд нийт албан хаагчдын амьдралын нөхцөлийн дэлгэрэнгүй судалгааг гаргаснаар 92 албан хаагчийн 60% нь орон сууцны урьдчилгаанд хамрагдах, 70% өөрийн эзэмшлийн газартай болох, 10% нь өөрийн гэсэн гэр оронтой болох чин хүсэлтэй байна. | |
| 40 | Арга хэмжээ 5.2.2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж ажиллах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Албан хаагчдын ажлын байран дээрх болзошгүй эрсдлийг бууруулах, эрүүл мэндийн дархлааг дэмжих зорилгоор, эрүүл мэндийн шинжилгээнд үндэслэсэн өдрийн эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | 96 |
| 41 | Арга хэмжээ 5.2.3. Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл, спорт хамтлаг залуучуудын зөвлөлийн санаачилга, төлөвлөгөөг дэмжиж, хэрэгжүүлэх. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Эцэг эхийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан төвийн албан хаагчдын 0-18 насны 128 хүүхдэд, 1 хүүхдийн 40 мянган төгрөг, нийт 5,120,000 төгрөгийн үнэ бүхий бэлгийн эрхийн бичгийг эцэг эхчүүдээр нь дамжуулан олгож ажилласан.<br>Төлөвлөгөөний хүрээнд Спорт залуучуудын зөвлөлөөс дараах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Албан хаагчдын дунд нөхөрсөг спортын тэмцээн зохион байгуулж, гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, ширээний теннис, даам зэрэг спортын 5 төрлөөр 7 баг оролцон нэг өдрийг идэвхтэй хөдөлгөөнөөр өнгөрүүлсэн нь спортыг дэмжсэн үр дүнтэй ажил болсон. | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн “Улаанбаатар-Марафон 2026” арга хэмжээнд байгууллагын 50 албан хаагч хөгжөөн дэмжиж, 10 ажилтан 21 км, 10 км, 5 км-ийн гүйлтийн төрөлд идэвхтэй оролцсон.<br>Түүнчлэн байгууллагын хаврын эко аяллыг зохион байгуулсан нь албан хаагчдын уур амьсгалыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. | |
| 42 | Арга хэмжээ 5.2.5. Сургалт хөгжлийн цогцолбор төв хотын төвлөрсөн дэд бүтэц, нийтийн тээврийн маршрутаас алслагдсан тул тус төвд ажиллах албан хаагчдад газар эзэмшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх. | | Шийдвэрийн тоо | | 1 | Нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу БЗД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Мэндсайхан, Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Мандуул нарт албан бичиг хүргүүлэн, хамтран ажиллаж 2 албан хаагчид БЗД-ийн 35-р хороо, Налайх дүүргийн 6-р хороонд тус тус өөрийн эзэмшлийн 700м2 газар олгох ажлыг зохион байгуулсан. | 90 |
| Зорилт 5.3. Мэдээллийн ил тод байдлыг хангах | | | | | | | |
| 43 | Арга хэмжээ 5.3.1 Төвийн худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны /tender.gov.mn/ цахим системээр зохион байгуулах. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх. | | Тендер зарлах багцын тоо | 3 | 2 | Төвийн даргын 2026 оны 04 сарын 15-ний өдрийн А/15 тоот тушаалаар 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1,277,000.000 төгрөгийн тендерийг 4 багц болгон зохион байгуулж Үүнд: нээлттэй-1, харьцуулалтын аргаар 3 тендер зарлагдсанаас нээлттэй-1, харьцуулалтын аргын-2 тендерт оролцогч шалгарч, гэрээ байгуулах бэлтгэл ажил хангагдаж байна. Харьцуулалтын аргаар зарласан 1 тендер оролцогчгүй байсан тул 3 дахь удаагаа зарлаж байна. | 90 |
| 44 | Арга хэмжээ 5.3.2. Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, зөрчил дутагдалгүй ажиллах, санхүүгийн программыг онлайнд шилжүүлж санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах. | | Тайлангийн тоо | 4 | 4 | 2025 оны санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж Нийслэл дэх Төрийн аудитын газраар аудит хийлгэн өөрчлөлтгүй санал дүгнэлт авсан. 2026 онд 6,524,243,000 төгрөгийн төсөв батлагдсан. 06 дугаар сарын байдлаар төсвийн хэтрэлтгүй, өр авлага бүртгэгдээгүй ажиллаж байна. 2026 онд санхүүгийн FISCUS программыг онлайн хувилбарт оруулан төвийн нягтлан нярвуудыг чадавхжуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | Арга хэмжээ 5.3.3. Шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт төсөв санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, тогтмол шинэчилж ажиллах. | | Мэдээллийн тоо | 171 | 171 | 2026 онд шилэн дансны цахим хуудсанд эхний 5 сарын байдлаар шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд 65 мэдээлэл нийтэлсэн. Мэдээллийн самбарт төсөв санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, тогтмол шинэчилж байна. | 100 |
| 46 | Арга хэмжээ 5.3.4. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төлөвлөгөө боловсруулж батлуулан хамт олны хурал, байгууллагын мэдээллийн самбар, дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад авлигын эсрэг мэдээллийг тогтмол өгч ажилласан. | 98 |
| 47 | Арга хэмжээ 5.3.5. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2026 онд байгууллагын бүтэц шинэчлэгдэж бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Ёс зүйн дэд хороо шинэчлэн байгуулагдаж, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлан хэрэгжүүлж, эхний хагас жилийн хугацаанд төвийн албан хаагчдад нийт 4 удаа сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлж ажилласан.<br>Мөн ёс зүйн хороонд ирсэн хоёр гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна. | 98 |
| Зорилт 5.4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах | | | | | | | |
| 48 | Арга хэмжээ 5.4.1. Хариуцсан чиг үүргийн хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх. | | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | Төвийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/158 дугаар захирамжид үндэслэн төвийн даргын 2025 оны А-01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог Захиргаа хүний нөөцийн удирдлага, Эрүүл мэнд нийгэм сэтгэл зүй хөдөлмөр эрхлэлт, Аж ахуй гэсэн 3 албатай баталж, удирдлага зохион байгуулалтын хувьд илүү оновчтой түвшинд шилжин ажиллаж байна. | 98 |
| 49 | Арга хэмжээ 5.4.5. nhtt.ub.gov.mn цахим хуудас, сошиал хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагааны онцлох мэдээллийг тухай бүр мэдээлж, төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажиллах. | | Мэдээллийн тоо | 135 | 150 | Байгууллагын веб сайт болон сошиал хуудасны дизайн, агуулгыг сайжруулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн ба давхардсан тоогоор 92 мэдээ, мэдээлэл веб сайт дээр нийтэлсэн байна. 2026 онд хамтын ажиллагаа, сургалт, олон нийт болон дотоод үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн болон онцлох мэдээ, мэдээлэл, контентыг боловсруулан байгууллагын фейсбүүк хуудсаар цаг тухай бүрд нийтэлж ажилласан. Фейсбүүк хуудсаар 62 удаагийн мэдээ, контент бэлтгэн нийтэлж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлсэн байна. | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 5.4.6. Дотоодын болон Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төслүүд дээр шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж гүйцэтгэлийг хангаж ажиллах. | | Хамтын ажиллагааны тоо | 10 | 20 | БНСУ-ын Хан мөрнийг хамгаалах хөдөлгөөний төв ТББ-тай 2025 онд хийсэн хамтран ажиллах санамж бичгийн дагуу 2026 онд Нийгмийн хамгааллын тусгай төвд тус байгууллагын төлөөлөл 2026 оны 8-р сард буюу 2 дахь удаагаа зочилж, хандив өгөх үйл ажиллагааг зохион байгуулах хөтөлбөр, бэлтгэл ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.<br>Түүнчлэн тайлангийн хугацаанд Сургалт хөгжлийн цогцолбор төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч Тэмээн ХХК, Сод Монгол группийн Улаанбаатар хот дахь нефт хангамжийн газар, Бялхам хайр ТББ, СХД-ийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Дэээрэт олон улсын энэрлийн байгууллага, Зөв найзууд НҮТББ, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар зэрэг байгууллагууд, хувь хүмүүстэй хамтран ажиллаж төвөөр үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ажлын байрны зуучлал, сургалт соён гэгээрлийн үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ сургалт, бичгийн хэрэглэгдэхүүн, модны тарьц суулгац зэрэг шууд хандив туслалцааг бүрдүүлэн ажилласан байна.<br>Дэээрэт ОУ-ын энэрлийн байгууллагад 2025 онд хүргүүлсэн төслийн саналын хүрээнд шинээр ашиглалтад орсон Сургалт хөгжлийн цогцолбор төвийн сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө, заслын өрөөг стандартад нийцүүлэн 6,5 сая төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн тохижуулж ажилласнаар сэтгэл зүйн үйлчилгээний орчны стандарт хэрэгжиж, үр дүн гарч эхлээд байна. | 93 |
| 50 | Арга хэмжээ 5.4.7. Салбарын байгууллагуудын чадавх бэхжүүлэх зорилтын хүрээнд төрийн бус байгууллага, төрийн байгууллагуудын дунд "Нэгэн зүгт хамтдаа" спорт тэмцээн, зөвлөлдөх уулзалт, өдөрлөг зохион байгуулах. | | Өдөрлөгийн тоо | - | 3 | Хамт олны идэвх оролцоо, багаар ажиллах чадвар, эрүүл амьдралын хэв маяг, спорт дасгал хөдөлгөөний дэмжих зорилгоор албан хаагчдын дунд спортын 5 төрөлт нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, нийт 7 багийн 56 албан хаагч оролцож, байр эзэлсэн байна.<br>"Нэгэн зүгт хамтдаа" тэмцээний талаар ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай санал солилцож 2026 оны намар уг тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 96 |
| 51 | Арга хэмжээ 5.4.9. Байгууллагын дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөө | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын 1 дүгээр улирлын ур чадварын үнэлгээнд дотоод хяналт | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | | | | хийж ажилласан бөгөөд 2026 оноос төвийн үйл ажиллагаа өргөжиж, шинэ салбар төв нээгдсэнтэй холбогдуулан дотоод хяналтын хийх аргачлалыг шинэчилж ажилласан бөгөөд, албан хаагчдын ажлын байранд 2026 оны 2 дугаар хагаст дотоод хяналт хийхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>Түүнчлэн байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуулийн хугацаанд дээд байгууллагад биелэлтийг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 52 | Арга хэмжээ 5.4.10. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж, төрийн өмчийн бүртгэлийн системийн ажиллагааг нэвтрүүлэх. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын 2026 оны төлөвлөгөөний дагуу ажиллаж, төрийн өмчийн бүртгэлийн системийг нэвтрүүлэн, 2025 оны үндсэн хөрөнгийн бүртгэлийн тайланг баталгаажуулсан.<br>Түүнчлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 143 дугаар тогтоолын дагуу Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл 2026 оны улсын үзлэг тооллогыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Чиглэл ХХК, Интерволд ХХК-аас үйлчлүүлэгчдийн өрөө тасалгаа, гал тогоо, оффисын хэрэглээ, сургалт, урлаг спортын болон автомашин зэрэг 170 гаруй тоног төхөөрөмжийг хүлээн авч анхан шатны баримтыг бүрдүүлэн Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас хөрөнгө шилжүүлэн авах ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 96 |
| Зорилт 5.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй | | | | | | | |
| 53 | Арга хэмжээ 5.5.1. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөний дагуу ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон үйлчлүүлэгч иргэдийн амьдрах орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад хяналт тавьж, холбогдох хууль, журмын дагуу аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангаж ажиллах. | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Сургалт хөгжлийн цогцолбор төв дээр галын дүгнэлт гаргуулж ХАБЭА-н самбар, галын булан, галын хор, байршуулсан. БЗД-ийн Онцгой байдлын газарт Сургалт хөгжлийн цогцолбор төв дээр галын дүгнэлт гаргуулах тухай албан хүсэлт хүргүүлсэн.<br>Дамжин өнгөрүүлэх төв дээр ХАБЭА-н самбар байрлуулж, хоёр төвийн самбарын мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь сайжруулж, шинэчлэн ажиллаж байна.<br>Лектор Чила Г.Бандицэрэнг урьж хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн нийт албан хаагчдын дунд сургалт зохион байгуулсан. | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сургалт хөгжлийн цогцолбор төвийн уурын зуух, Дамжин өнгөрүүлэх төв дээр тус тус эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл учирч болзошгүй зүйлсийг тухай бүрд засаж сайжруулсан. | |
| Зорилт 5.6. Мэдээллийн технологи | | | | | | | |
| 54 | Арга хэмжээ 5.6.1. Байгууллагын дотоод бүртгэлийн программын үйл ажиллагааг сайжруулж, шинэчлэн, интернэт, программ хангамж, компьютер тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хանган ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Сургалт хөгжлийн цогцолбор төвийн дотоод сүлжээний холболтын ажлын хүрээнд 240 лангийн толгой, 7 рүүтэр, 8 свичийг суурилуулан сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, 27 албан хаагчийн компьютерыг угсарч шаардлагатай программ хангамж болон вирусийн хамгаалалтын программыг тохируулан суулгасан. Мөн 6 принтерийг дотоод сүлжээнд холбон драйверын тохиргоог хийж, хэвийн ажиллагааг хангаж ажилласнаар байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийн суурилуулалт, тохиргооны ажил бүрэн дууссан байна.<br>93 албан хаагчийг цаг бүртгэлийн системд бүрэн хамруулж, Хүний нөөцийн ажилтанд ERP системийн ашиглалттай холбоотой арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>Байгууллагын IT тоног төхөөрөмж, программ хангамж, интернэтийн үйлчилгээ авах гэрээг Микросити ХХК компанитай байгуулан хэрэгжүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлсэн. Энэхүү ажлаар байгууллагын дотоод цахим орчин болон IT системийн ажиллагааг тогтворжуулав. | 98 |
| 55 | Арга хэмжээ 5.6.2. Цахим технологи ашиглан төвөөр үйлчлүүлэгч иргэдийн бүртгэл мэдээллийн системийг шинэчлэн ажиллах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын дотоод бүртгэлийн программын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх ажлын хүрээнд бүртгэлийн программыг нийт 6 ажилтны компьютерт суурилуулж, ашиглалтад оруулсан. | 98 |
| Зорилт 5.7.Архив, албан хэрэг хөтлөлт | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | Арга хэмжээ 5.7.1. Архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, журмын дагуу хөтлөн явуулж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp, ulaanbaatar.mn, цахим хуудсыг ашиглах. | | Албан бичиг шийдвэрлэлтийн хугацаа /хоног/ | 9 | 8 | Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, журам, зааврын дагуу зохион байгуулж, ERP, ulaanbaatar.mn болон бусад цахим системийг тогтмол ашиглан ажилласан. Тайлант хугацаанд 104 ирсэн бичгээс 96-г шийдвэрлэж, 8 нь судлагдаж байгаа бөгөөд шийдвэрлэлтийн хувь 95.35, дундаж хугацаа 7.23 хоног байна. Мөн 68 албан бичгийг холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлэн, бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг цахим системд тухай бүр бүртгэн хяналт тавин ажилласан. | 95 |
| 57 | Арга хэмжээ 5.7.2. Иргэдийн өргөдөл гомдлыг цахим болон бусад хэлбэрээр хүлээн авч шуурхай шийдвэрлэх. | | Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоног/ | 6 | 5 | Иргэд, албан хаагчдаас нийт 85 өргөдөл, хүсэлт, талархлыг хүлээн авч системд бүртгэж ажилласан. Үүнээс:<br>-Шийдвэрлэсэн: 83<br>-Судалж байгаа: 2<br>-Шийдвэрлэлтийн хувь: 97% байна.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног, 11 цаг 47 минут.<br>Өргөдөл, гомдлын 97 хувийг хугацаанд нь шийдвэрлэснээр иргэд, албан хаагчдын санал хүсэлт шуурхай шийдэгдэж, сэтгэл ханамж нэмэгдэн, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага сайжирсан. | 97 |
| 58 | Арга хэмжээ 5.7.3. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн хэвшиж, албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS 6395:2022 стандартын дагуу монгол бичгээр тушаал 116, А4 албан бичиг 37, А5 албан бичиг 44, тодорхойлолт 12 ширхгийг тус тус боловсруулж, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн хэвшүүлсэн. | 98 |
| 59 | Арга хэмжээ 5.7.4. Төвийн дарга хуваарийн дагуу үйлчлүүлэгч иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, байгууллагын төлөвлөгөөнд тусгаж ажиллах. | | Уулзалтын тоо | 8 | 8 | Төвийн дарга Ш.Мөнхцэцэг нь 2026 оны 02 дугаар сарын 23, 03 дугаар сарын 08, 19-20, 05 дугаар сарын 06, 16-ны өдрүүдэд үйлчлүүлэгч иргэдтэй 5 удаагийн уулзалтаар, нийт 229 иргэнтэй уулзсан байна. Уулзалтын үеэр иргэдийн тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан байна. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | Арга хэмжээ 5.7.5. Тогтоол шийдвэр, захирамжийг цаг тухайд нь хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тухай бүр тайлагнах. | | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэр, захирамжийн биелэлтийг хангаж, гүйцэтгэл гарган, тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. | 95 |
| 61 | Арга хэмжээ 5.7.6. Баримт нягтлан шалгах комиссын төлөвлөгөөний дагуу ажилтнуудын албан хэрэг хөтлөлт, бичиг баримтад стандартын дагуу зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллах. | | Зөвлөгөө өгч хяналт тавих ажил зохион байгуулсан тоо | 2 | 4 | Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурал 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан. Хурлаар комиссын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, албан хаагчдаас ирүүлсэн санал үндэслэн Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулсан. Мөн байгууллагын архивын журмыг нийт албан хаагчдад танилцуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна. | 96 |
| Зорилт 5.8. Тохижилт, аж ахуйн чиглэлээр | | | | | | | |
| 62 | Арга хэмжээ 5.8.1. Үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчныг сайжруулж байгууллагын салбар төвүүдийн дотоод болон гадна тохижилт, урсгал засварын ажлыг гүйцэтгэх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Дамжин өнгөрүүлэх төв болон Сургалт хөгжлийн цогцолбор төвийн үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчин, төвүүдийн гадна, дотоод урсгал засварын ажлын гүйцэтгэл 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчин, төвүүдийн гадна дотно тохижилт, урсгал засварын ажлыг төлөвлөгөөний дагуу 3 дугаар улиралд бүрэн хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Дамжин өнгөрүүлэх төвийн үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчныг сайжруулах, гадна, дотно тохижилт, урсгал засварын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- Дамжин өнгөрүүлэх төвийн сантехник, цахилгааны үзлэг шалгалтыг хийж, урсгал засварыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.<br>- Гал тогооны агаар сэлгэлтийн системийг бүрэн шинэчлэн ажиллах орчныг сайжруулан, нэг өрөөг жишиг өрөө болгон тохижилтыг бүрэн хийж дуусгасан болно.<br>- Дамжин өнгөрүүлэх тавийн ард шинээр баригдсан орон сууцны гүйцэтгэгч компанид хүсэлт тавьж гадна үүдний хэсгийн зам талбайг асфальтан хучилттай болгож ажилласнаар орох гарах гарц аюулгүй, илүү тав тухтай боллоо. | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Үйлчлүүлэгч иргэдийн гадна байрлах гэрүүдийг буулган цэгцлэн дахин барьж, цагаан бүрээсийг сольсон болно.<br>- Ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу гадна, дотно цэцэрлэгжүүлэлт, зүлэг хийхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хийсэн бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 12-ны дотор тарихаар төлөвлөн ажиллаж байна.<br>Модны тайралт, хэлбэржүүлэлд хийн хашаан доторх модны өнгө үзэмжийг сайжруулсан.<br>Сургалт хөгжлийн цогцолбор төвийн үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчныг сайжруулах, гадна, дотно тохижилт, урсгал засварын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зорилтод бүлгийн иргэдийг хүлээн авах ажлын хүрээнд үйлчлүүлэгчдийн түр байрлах өрөө, ажилтан албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах, тоног төхөөрөмж, тавилгыг хуваарилах, өрөө бүрийн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Сантехник, цахилгааны үзлэг шалгалтыг хийж, урсгал засварыг тухай бүр биелэлтийг хангаж ажилласан.<br>- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар тендерт шалгарсан гүйцэтгэгч “Тэмээн” ХХК, “Интерворлд” ХХК-аас захиалсан тоног төхөөрөмж, автомашин, барилга байгууламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж, 85 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.<br>- УБЦТС ТӨХК, Ус сувгийн удирдах газар, Хог тээврийн “Гонир гоулд” ХХК-тай төрийн байгууллагуудын уялдааг бэхжүүлэх зорилгоор үйлчилгээ авах тухай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>- БЗД-ийн 35 дугаар хорооноос Сургалт хөгжлийн цогцолбор төв хүртэлх 2,5 км шороон замын хөрс доош сууж бохирын машин, ажилчдын автомашин явахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул БЗД-ийн 35 дугаар хороо, Тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ, Улаанбаатар зам засвар арчилгааны газартай хамтран доош суусан хөрсийг хайрга, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дайргаар хучин холбогдох арга хэмжээ авч ажилласан.<br>- “Хүн бүр мод тарья” аяны арга хэмжээний хүрээнд 130 ширхэг нарс, 500 ширхэг шар хуайс, шинэс, агч, голт бор зэрэг модыг тарьж, орчны ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн байна. | |
| **НИЙТ** | | | | | | | 97,9 |

ХЯНАСАН:
ДАРГА Ш.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Э.ПҮРЭВСҮРЭН